



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн “Байгальнаран” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/234/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 11315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
“Ворлдвайд файнэнс Аудит” ХХК-ийн захирал: С.Оюунгэрэл
Утас: 99032466 Цахим хаяг: oyungerels.sag@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------------------------------|-----------------------|-----------------------|
| ХӨРӨНГӨ | | |
| Эргэлтийн хөрөнгө | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 77,085.21 | 1,249,031.90 |
| Дансны авлага | 22,916,041.52 | 7,488,234.12 |
| Бараа материал | 15,610,876.85 | 12,171,893.35 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 38,604,003.58 | 20,909,159.37 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 165,997,183.44 | 141,905,502.27 |
| Биет бус хөрөнгө | | |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 165,997,183.44 | 141,905,502.27 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 204,601,187.02 | 162,814,661.64 |
| ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| Өр төлбөр | | |
| Богино хугацаат өр төлбөр | | |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | | |
| Өр төлбөрийн нийт дүн | 0.00 | 0.00 |
| Эзэмшигчдийн өмч | 64,758,063 | 64,758,063 |
| Төрийн | 64,688,063 | 64,688,063 |
| Хувийн | 70,000.00 | 70,000.00 |
| Хуримтлагдсан ашиг | 139,843,124.02 | 98,056,598.64 |
| Эзэмшигчдийн өмчийн дүн | 204,601,187.02 | 162,814,661.64 |
| НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | 204,601,187.02 | 162,814,661.64 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|----------------------|-----------------------|
| Борлуулалтын орлогын дүн | | |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | |
| Нийт ашиг (алдагдал) | | |
| Бусад орлого | 719,511,090.13 | 637,849,337.81 |
| Борлуулалт, маркетингийн зардал | | |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 636,085,299.13 | 679,635,863.19 |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 83,425,791.00 | -41,786,525.38 |
| Орлогын татварын зардал | | |
| Татварын дараах ашиг (алдагдал) | 83,425,791.00 | -41,786,525.38 |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | - | - |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 83,425,791.00 | -41,786,525.38 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|-----------------------|-----------------------|
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ | | |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | 607,652,094.51 | 645,112,558.55 |
| Татаас, санхүүжилтийн орлого | 607,652,094.51 | 645,112,558.55 |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | 606,397,061.89 | 641,340,711.86 |
| Ажиллагчдад төлсөн | 465,118,599.00 | 496,025,609.00 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 57,347,323.77 | 59,936,706.54 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 37,305,810.81 | 31,531,529.57 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 8,145,012.00 | 9,029,774.30 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 3,471,981.00 | 3,570,000.00 |
| Бусад мөнгөн зарлага | 35,008,335.31 | 41,247,092.45 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 1,255,032.62 | 3,771,846.69 |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ | | |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн | - | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | - |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн | 2,027,700.00 | 2,599,900.00 |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө | 2,027,700.00 | 2,599,900.00 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (2,027,700.00) | (2,599,900.00) |
| Санхүүгийн мөнгөн гүйлгээ | | |
| Санхүүгийн мөнгөн орлогын дүн | | |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | | |
| Санхүүгийн мөнгөн зарлагын дүн | - | - |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | | |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн | - | - |
| Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | (772,667.38) | 1,171,946.69 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 849,752.59 | 77,085.21 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 77,085.21 | 1,249,031.90 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|--|----------------------|------------------------|-------------------------------------|-----------------------------------|---------------------------|-----------------------|-----------------------|
| 2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 64,758,063.00 | - | - | - | - | 56,417,333.02 | 121,175,396.02 |
| Зарласан ногдол ашиг | | . | | | | - | - |
| Өмчит гарсан өөрчлөлт | | | | | - | | |
| Тайлант үеийн ашиг | | | | | | 83,425,791.00 | 83,425,791.0 |
| 2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 64,758,063.00 | - | - | - | - | 139,843,124.02 | 204,601,187.02 |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | | - | - |
| Залруулсан үлдэгдэл | | - | - | - | - | - | - |
| Зарласан ногдол ашиг | | . | | | | - | - |
| Өмчит гарсан өөрчлөлт | | | | | - | | - |
| Тайлант үеийн ашиг | | | | | | (41,786,525.38) | (41,786,525.38) |
| 2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 64,758,063.00 | - | - | - | - | 98,056,598.64 | 162,814,661.64 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 19,542.0 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Тайлант хугацаанд санхүүгийн байдлын тайлан дахь Төрийн өмчийн дүнг 190.0 мянган төгрөгөөр бууруулсныг залруулав.
- Машин тоног төхөөрөмжид бүртгэлтэй 17,906.0 мянган төгрөгийн үнэ бүхий 24 ширхэг компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгүүлж, алдааг залруулсан.
- Орлогын дэлгэрэнгүй тайлангийн бичиг хэргийн зардлыг 1,446.0 мянган төгрөгөөр бараа материалын тайлангаас илүү бүртгэснийг залруулсан.

Эдгээр нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга-ын 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой", НББОУС 16: Үндсэн хөрөнгө "үндсэн хөрөнгийн анги тус бүрийн ... тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ...", Сангийн сайдын 2017 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-д...Компьютер, бусад хэрэгсэл-ийг ангилан бүртгэнэ" гэсэн заалтууд болон санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "ангилал", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 2,200.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлж, 4,275.6 мянган төгрөгийн зөрчлийг² арилгах 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 6,475.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

Эрүүл мэндийн даатгалын багцын тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанартай хүргэж гүйцэтгэх ажилд ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хуваариар хамааралгүй атал ӨЭМТ-ийн даргын 2025 оны 9 удаагийн тушаалаар нягтлан бодогчид 2,200.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3.1.7 "эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц" гэж даатгуулагчид үзүүлэх зайлшгүй хэрэгцээтэй оношлох, эрт илрүүлэх, эмчлэх, сэргээн засах, асрах, сувилах, хөнгөвчлөх болон эмийн үнийн хөнгөлөлтийг багтаасан эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нийцүүлэн урамшууллыг олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Өмнөх онд олгоогүй амралтын мөнгө 4,275.6 мянган төгрөгийг өглөгт бүртгээгүй, тайлант онд олгож, үр дүнг бууруулсан. Энэ нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4.3-т "бүх өр төлбөр"-г нягтлан бодох бүртгэлд... заавал бүртгэнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "тасалбар болголт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлж, ажил гүйлгээг зөв тайлант хугацаанд бүртгэж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|-------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| "Байгальнаран" ӨЭМТ-ийн 2025 оны жилийн эцсийн Санхүүгийн байдлын тайлан дахь Засгийн газрын хувь оролцооны Төрийн өмчийн дүн оны эхэнд 64,688,063 төгрөг байсныг оны эцэст 64,498,063 төгрөг болгож бууруулсан байна. | 1 | 190.0 | | | 1 | 190.0 | 1 | 190.0 | | | | |
| Машин тоног төхөөрөмжид бүртгэлтэй 24 ширхэг компьютер бусад хэрэгслийг "компьютер бусад хэрэгсэл"-д ангилан бүртгүүлж, алдааг залруулсан. | 1 | 17,906.0 | | | 1 | 17,906.0 | 1 | 17,906.0 | | | | |
| Орлогын дэлгэрэнгүй тайланд бичиг хэргийн зардлыг илүү бүртгэсэн. | 1 | 1,446.0 | | | 1 | 1,446.0 | 1 | 1,446.0 | | | | |
| Дүн | 1 | 19,542.0 | | | 1 | 19,542.0 | 1 | 19,542.0 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|----------------|---------------|-----|-----------------|----------------|----------|----------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрүүл мэндийн даатгалын багцын тусламж үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй чанартай хүргэж гүйцэтгэх ажилд ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хуваариар хамааралгүй нягтлан бодогчид ӨЭМТ-ийн даргын 2025 оны 9 удаагийн тушаалаар 2,200.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. | 1 | 2,200.0 | | | 1 | 2,200.0 | | |
| Өмнөх онд олгоогүй ээлжийн амралтын мөнгийг өглөгт бүртгээгүй, тайлант онд олгож, үр дүнг бууруулсан. | 1 | 4,275.6 | | | | | 1 | 4,275.6 |
| Дүн | 1 | 6,475.6 | | | 1 | 2,200.0 | 1 | 4,275.6 |

